

CEO SURVEY
REPORT 2023



nCD GROUP
НОГООН ИРЭЭДҮЙГ БҮТЭЭНЭ

VEGA⁺
CITY

Амьдрах орчны тав тухыг бүрэн хангах,
бүс нутгийнхаа хамгийн том ногоон байгууламжтай
VEGA CITY цогцолбор ногоон хотхон



Та энэхүү QR кодыг
ашиглан дэлгэрэнгүй
мэдээлэл авах боломжтой.

ХУД, 15-р хороо, "Орчлон" ОУ-ын
дүнд сургуулийн баруун талд

☎ 7577-7577

Талархал

CEO survey 2023 нь Монгол Улсын эдийн засаг, бизнесийн орчны өнөөгийн төлөв байдал, цаашдын хүлээлт, зах зээлийн боломж, өсөлтийг хангахтай холбоотой тулгамдаж буй асуудал, саад бэрхшээл болон хөрөнгө оруулалт, засаглал, хүний нөөц, дижитал шилжилт, дата аналитик AI хүрээнд баримталж буй бодлого, стратегийн тэргүүлэх чиглэлийг тодруулах зорилготой тогтмол хийгдэх судалгаа юм.

Судалгаанд оролцож санал бодлоо илэрхийлсэн ТОП-54 CEO, дизайны ажлыг хийж гүйцэтгэсэн Brainstorm Branding Agency нартаа хувийн хэвшлийн хөгжилд оруулж буй хувь нэмэрт нь гүн талархал илэрхийлье.

Санаачилж гүйцэтгэсэн

Үндэсний судалгааны MMCG компанийн баг хамт олноос



АГУУЛГА

| | | | | |
|--|---|--|---|----------------------------|
| Нэг. Хүлээлт ба саад бэрхшээл | Хоёр. Өсөлтийг хангах чиглэл | Гурав. Хөрөнгө оруулалтын гол чиглэл | Дөрөв. Хүний нөөцийн бодлого | Тав. Гол дүгнэлт |
| 11 | 18 | 29 | 36 | 43 |

СУДАЛГААНД ОРОЛЦСОН КОМПАНИУД



MMCG: CEO SURVEY 2023-Д ОРОЛЦСОН НИЙТ CEO НАР



CEO SURVEY

ГОЛ ҮР ДҮН

01

2024 оны Монгол Улсын эдийн засаг 5 хувьтай өсөхөөр эерэг хүлээлттэй байна.

02

Хөрөнгө оруулалтын шийдвэрүүд сонгуулийн үр дүнгээс хамаарч хүлээгдэж байгаа нь эдийн засгийн өсөлтийг удаашруулж байна.

03

Эдийн засгийн өсөлт нь ажиллах хүчний дутагдал, ур чадварын хомсдол, эрчим хүчний хомсдол зэрэг асуудлуудаар хязгаарлагдаж болзошгүй байна.

04

ТОП компаниудын 60 хувьд нь үйл ажиллагааны зардал нэмэгдэх төлөвтэй байна.

05

Гүйцэтгэх захирлуудын 72 хувь нь бизнес дэх төрийн оролцоог өндөр байна гэж үзэж байна.

06

Төрийн шийдвэрүүд тогтвортой биш, зөвшөөрөл нь удаашралтай байгаа нь бизнесийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна.

07

Бизнесийн төлөөллийн байгууллагуудын үйл ажиллагааг гүйцэтгэх захирлуудын 58 хувь нь хангалтгүй байна гэж дүгнэлээ.

08

Ихэнх секторуудын тоглогчдын бизнес модель хоцрогдолтой, өрсөлдөх чадвар муу байгааг компаниудын 68 хувь нь зах зээлийн боломж гэж харж байна.

09

Бизнесүүдийн 50 хувь нь зорилтот хэрэглэгчээ судлахгүй, 64 хувь нь бүтээгдэхүүнээ туршихгүй, 75 хувь нь зах зээлд гарснаас хойш хэмжихгүй байгаа нь бизнес хөгжүүлэлтийн процесс хоцрогдолтой байгааг харуулж байна.

10

Нийт гүйцэтгэх захирлуудын 53 хувь нь одоогийн бизнес моделиор үргэлжлүүлэн ажиллавал дараагийн 5 жилд эдийн засгийн хувьд үр ашигтай байж чадахгүй гэж үзэж байна.

11

Компанийн стратегийн тэргүүлэх чиглэл нь бизнес моделейг сайжруулах, технологи, дижитал шилжилтийг үргэлжлүүлэн хийх асуудал байна.

12

Нийт компаниудын 60 гаруй хувь нь Big Data Analytics, AI-д анхаарлаа тавьж эхэлсэн байна.

13

Компаниудын 49 хувь нь шаардлагатай хөрөнгө оруулалт татах эх үүсвэрийг компанийн өөрийн хуримтлал, ашгаас хийхээр төлөвлөж байна.

14

Уул уурхайн салбараас гадна хүнс, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлд хөрөнгө оруулах сонирхол өндөр байна.

15

Барилгын салбар хөрөнгө оруулалт татах байдал хамгийн бага байна.

CEO
SURVEY

ГОЛ ҮР ДҮН

16

ТОП компаниудын 40 хувь нь ойрын 3 жилд үндсэн болон охин компани нээлттэй компани болгох төлөвлөгөөтэй байна.

17

Ажиллах хүчний эргэц 19 хувьтай байгаа нь хэвийн түвшнээс 2 дахин өндөр үзүүлэлт байна.

18

Нийт компаниудын 64 хувьд нь ажиллах хүчний хомсдол мэдрэгдэж эхэлсэн байна.

19

2023 онд цалингийн өсөлт дунджаар 24 хувьтай байсан бол цаашдаа ч дахин өсөх төлөвтэй байна.

20

Гүйцэтгэх захирлууд цалингаас гадна соёлоороо өрсөлдөж, ажилтны хүсэмжит байгууллага байхын тулд ажилтан төвтэй болох нь чухал гэдгийг онцолж байна.

CEO
ГОЛ ҮР ДҮН
SURVEY



Нэг.

ХҮЛЭЭЛТ БА СААД БЭРХШЭЭЛ


2024 ОНЫ ХҮЛЭЭЛТ ЭЭРЭГ БАЙНА ...


Дэлхийн эдийн засгийн өсөлтийг 2024 онд Олон Улсын Валютын Сан/IMF/, Дэлхийн банк/WB/, Bloomberg Global зэрэг олон улсын байгууллагууд дунджаар 2.6 хувь буюу бага зэргийн эерэг өсөлттэй байна гэж таамаглаж байна. Харин БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийг 4.2-4.4 хувиар өснө гэсэн таамаглалтай байна.


ХАРИН МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭЛХИЙН БАНК БОЛОН АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК 6 ХУВЬ, САНГИЙН ЯАМ 7 ХУВЬД ХҮРНЭ ГЭСЭН ХҮЛЭЭЛТТЭЙ БАЙГАА БОЛ МОНГОЛЫН ТОП 50 CEO НАР 5 ХУВЬД ХҮРНЭ ГЭСЭН ХҮЛЭЭЛТТЭЙ БАЙНА.

Дэлхийн хэмжээнд,
2023 оны 10 сарын байдлаар

ДНБ-ий өсөлт, %



 **Mongolia,**
2023 оны 10 сарын байдлаар





Дэлхийн болон Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн талаарх 2024 оны хүлээлт

2024 ОНД СОНГУУЛЬ + АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХОМСДОЛ ...

СЕО нар өсөлтөд хүрч чадахгүйд нөлөөлөх хамгийн гол дотоод хүчин зүйлийг УИХ-ын сонгууль гэж харж байгаа бөгөөд 2024 оны төсөв бүтээлч бус популист маягийн төсөв зарцуулагдах магадлалтай гэж үзэж байна. Хөрөнгө оруулалтын шийдвэрүүд сонгуулийн үр дүнгээс хамаарч хүлээгдэж байгаа нь эдийн засгийн өсөлтийг удаашруулах нэг хүчин зүйл болж байна. Үүнээс гадна ажиллах хүчний дутагдал, ур чадварын хомсдол, инфляц, эрчим хүчний хомсдол зэрэг асуудлуудаар хязгаарлагдаж болзошгүй байна.

Харин гадаад нөхцөл байдлын хувьд Орос-Украины дайн, БНХАУ, АНУ-ын нөхцөл байдал, геополитикийн зөрчилдөөн зэрэг тодорхойгүй асуудлууд байна. Мөн тээвэр, логистикийн асуудал хэдий сайжирсан ч гэсэн удаашралтай хэвээр байна.



2024 ОНЫ ХҮЛЭЭЛТ ЭЭРЭГ БАЙНА ...



2024 онд Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг сааруулж болзошгүй гадаад хүчин зүйл нь Европоос санхүүжилт орж ирэхэд Орос-Украины дайн хүндрэл учруулж байна. ОХУ-аас импортолж буй шатахуун, эрчим хүчний хараат байдлыг одоогоор бид шийдэж чадахгүй. Үүнээс гадна ам.долларын хомсдол болон мөн манай улсын санхүүгийн сахилга батгүй байдал нь асуудал болж байна.”

Р.Мөнхтуяа
ХААН банк ХК
Гүйцэтгэх захирал



Монгол Улсын эдийн засагт ээргээр нөлөөлж буй хүчин зүйлсийн нэг нь импортыг орлож буй бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэдэг болж байгаа явдал юм. Өмнө нь бүх талаараа хамааралтай байсан бол одоо зарим нэг салбарууд биеэ даах чадвартай болсон. Экспортын өсөлт импортын өсөлтөөс илүү хурдтай байгаа ба энэ нь уул уурхайн бүтээгдэхүүн дээр ажиглагдаж байна. Мөн түүнчлэн гадагшаа гарч байгаа таваарын урсгал эрс нэмэгдэж байна.”

Н.Мөнхнасан
Монполимет групп
ТУЗ-ийн дарга



Нийлүүлэлтийн сүлжээнээс шалтгаалан бид 100 бүтээгдэхүүний 20-ыг хугацаандаа авч чадахгүй байгаа нь хэрэглэгчээ гомдооход хүргэж байна. Тиймээс зах зээлийн өсөлтийг хангахын тулд нийлүүлэлтийн сүлжээг тогтвортой болгохыг зорьж байна.”

Г.Чинзориг
Сэнтрал Экспресс Си Ви Эс
Гүйцэтгэх захирал



Манай улсын хувьд ханшийн дарамт харьцангуй бага байна. Эндээс үндэслэхэд эдийн засаг 4-5 хувь өсөх эерэг хандлага харагдаж байна. Банк нь эдийн засгийн хамгийн том шийдвэрийг гаргадаг учраас банкны салбар өөрөө эдийн засгийн судас гэж явдаг. Хүний урсгал, гадаад дотоод гүйлгээ их байвал дагаад асуудалгүй хангалттай өсөлт байгаа гэж харж байна.”

А.Одонбаатар
Голомт банк ХК
Гүйцэтгэх захирал


ЗАХИРЛУУД ӨӨДРӨГ БАЙГАА Ч ЗАРДАЛ НЭМЭГДЭХ, УР ЧАДВАР ДУТАГДАХ БЭРХШЭЭЛ БАЙНА ...

Гүйцэтгэх удирдлагууд ирэх жилийн компанийн борлуулалтын орлогыг өснө гэсэн эерэг хүлээлттэй байгаа нь харагдаж байна. Түүнчлэн уг өсөлтийг хангахад саад болох бэрхшээлүүдийг үйл ажиллагааны зардал нэмэгдэх, компанийн ашигт ажиллагаа буурах, ажилтнуудын ур чадвар, бүтээмжийн тааруу байдал, дижитал шилжилтийн хоцрогдол гэж харж байна.


2024 онд танай компанийн борлуулалтын орлого хэрхэн өөрчлөгдөнө гэсэн хүлээлттэй байна вэ?

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

- Өндөр өсөлттэй
- Дунд өсөлттэй
- Бага өсөлттэй
- Хэлж мэдэхгүй



СААД, БЭРХШЭЭЛ



Танай компанийн өсөлтөд сөргөөр нөлөөлж буй дотоод асуудал, бэрхшээлийг юу гэж харж байна вэ?


ТӨРИЙН ШИЙДВЭРҮҮД НЬ ТОГТВОРТОЙ БИШ, УДААШРАЛТАЙ БАЙНА ...

Дэлхийн дахинд үүсээд буй эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд амжилттай давах, эдийн засгийг сэргээх хүндхэн үүрэг төр засаг ба хувийн хэвшилд ногдож байгаа учир төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг улам нэмэгдүүлэх нь чухал гэж үзэж байна.

Гүйцэтгэх захирлуудын 72 хувь нь бизнес дэх төрийн оролцоог их байна гэж хариулсан ба бизнес дэх төрийн оролцоо ихэссэнээр зохистой оролцоо алдагдаж, олон сөрөг үр дагавар, хүндрэл гардаг гэж үзэж байна.

Төрийн шийдвэрүүд нь тогтвортой биш, цаг хугацаа алдсан оновчгүй, бизнес хийхтэй холбоотой аливаа зөвшөөрөл, процедур нь төвөгшил ихтэй, удаашралтай байдаг нь бизнесийн хурд болон өсөлтөд хамгийн их саад болж байна.

БИЗНЕС ДЭХ ТӨРИЙН ОРОЛЦОО



Та бизнес дэх төрийн оролцоог хэр түвшинд байдаг гэж дүгнэнэ вэ?




Төрийн урт хугацааны бодлого, дэмжлэг хэрэгтэй байна. Бизнес дэх төрийн оролцоо маш их байна. Төр бүхий л салбарт стандартаа тогтоож өгөөд хувийн хэвшлийн хийж чадах ажилд оролцохгүй байх хэрэгтэй.”



Л.Огторгуй

Би Ти Эф ХХК-ийн үүсгэн байгуулагч, захирал

ТӨЛӨӨЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Төлөөллийн байгууллагууд бизнес эрхлэгчдийн дуу хоолойг төрд хүргэх, эрх ашгийг хамгаалах чиглэлд хэр түвшинд ажиллаж байна вэ?

ТӨЛӨӨЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МУУ ДҮН ТАВИЛАА ...

Бизнес эрхлэгчдийн ярьж буй гол зүйл бол төлөөллийн байгууллагууд бизнес эрхлэгчдийн дуу хоолойг төрд хүргэх, эрх ашгийг хамгаалах чиглэлд хангалтгүй тааруу ажилладаг буюу судалгаанд оролцогчдын 58 хувь нь төлөөллийн байгууллагын үйл ажиллагаанд муу гэсэн үнэлгээ өгсөн.

Мөн төлөөллийн байгууллага нь тодорхой аж ахуйн нэгжүүдийн эрх ашгийг хамгаалахаас илүү тухайн бизнесийн кластеруудын өртгийн гинжин хэлхээний хүрээнд харж шинэчлэх, хүндрэлтэй байгаа асуудлуудыг мэргэжлийн байгууллага болон холбоодтой хамтарч тодорхойлдог байх хэрэгтэй. Мөн тухайн асуудлууд дээр төрийн шийдвэрлэх зүйлсийг тодорхойлж, засгийн газрын холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэх чиглэлд судалгаа шинжилгээтэй, үл үндэстэй ажилладаг тогтолцоо руу шилжих нэн шаардлагатай байна.



Хоёр.

ӨСӨЛТИЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛ

ИННОВАЦ НЬ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ ГОЛ ЧИГЛЭЛ БАЙНА ...

CEO нарын харж байгаа өнцөг нь сул зах зээл, шинэ орон зай гэхээс илүү ихэнх секторуудын тоглогчдын бизнес модель хоцрогдолтой, өрсөлдөх чадвар муу байгаа гэж үзэж байна. Энэ нь тухайн зах зээлд нэвтрэх боломж потенциал өндөр байгааг харуулж байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН БОЛОМЖ, ПОТЕНЦИАЛ БИЙ...

76%²⁰²⁰ → **68%**²⁰²³

McKinsey & Company

"61% Redesign Product and Service"
CEO Survey -2023:



Зах зээлийн өсөлтийг хангах хамгийн гол чиглэлийг CEO нарын 55 хувь нь бүтээгдэхүүн, үйлчилгээндээ инновац шингээх буюу бизнес моделийн өрсөлдөх чадварыг сайжруулан үнэ цэнийг өсгөснөөр аливаа салбарт нэвтрэх боломжтой гэж харж байна. Түүний дараагаар хүмүүсийн амьдралын хэв маяг илүү дижитал хэлбэрт шилжиж буй энэ үед дотоод үйл ажиллагаандаа болон бүтээгдэхүүн үйлчилгээ рүү дижитал шилжилт, шинэ технологи, платформ нэвтрүүлэх гэсэн чиглэлүүдийг барьж байна.

МСКИНСЕY КОМПАНИЙН СУДАЛГААГААР БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНДЭЭ ИННОВАЦ ШИНГЭЭЖ, БИЗНЕС МОДЕЛИО ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГА ОЛОН УЛСАД Ч АДИЛХАН ӨНДӨР БАЙГААГ ХАРУУЛЖ БАЙНА.

ИННОВАЦ НЬ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ ГОЛ ЧИГЛЭЛ БАЙХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА ...

Бизнес эрхлэгчид болон хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн огтлолцол дээр амжилттай бизнес оршдог тул аль аль талаас нь судалж байж ажлаа хийх хэрэгтэйг онцолж байв.



Дэлхий хурдацтай хувьсан өөрчлөгдөж эдийн засгийн хүндийн төв баруунаас зүүн тийш чиглэж байгаа энэ үед шинэ бизнес, шинэ боломж асар их гарч ирнэ.”

О.Тэнүүн
Оюуны Ундраа Пропертиз
ТУЗ-ийн дарга



Бүтээгдэхүүн, үйлчилгээндээ инновац шингээж, үнэ цэнээ өсгөх болон дотоод үйл ажиллагаандаа шинэ технологи, платформ нэвтрүүлэхийг гол чиглэл гэж харж байна. B2B зах зээлд илүү их ажилладаг тул тэдэнд зориулж илүү их инновацлаг, лаборатори байгуулж, газар дээр нь очиж туршилт хийх зэрэг шийдлийг хамт олоход нь ноу-хау шингээж ажилладаг. Манай гол эрэлтийг үүсгэж буй зүйл бол чанар юм.”

Н.Мөнхнасан
Монполимет групп
ТУЗ-ийн дарга



Байгуулагдсан цагаасаа хойш бүтээгдэхүүн хөгжүүлэлтээ тасралтгүй хийсээр өдгөө 14 брэндийн 100 гаруй төрлийн сүү, сүүн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж байна. “Витафит милк” компанийн алсын хараа бол салбарын зах зээлдээ шинэ жишиг тогтоох, хэрэглэгчдэд чанартай эрүүл мэндийн үнэ цэн өгөхөд чиглэж буй. 2025 он гэхэд шинэ үйлдвэрээ ашиглалтад оруулж, инновацлаг шинэ бүтээгдэхүүнүүд хөгжүүлж, зах зээлд нэвтрүүлэх төлөвлөгөөтэй байна.”

С.Болорсайхан
Витафит милк ХХК
Гүйцэтгэх захирал



Бизнесийн экосистемийг бий болгосноор салбар бүрд бүтээмж нэмэгдэж, тогтмол болон хувьсах зардал буурна. Ингэснээр хэрэглэгчдэд илүү инновац шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээ хүргэдэг.”

Б.Алтангэрэл
Грийн групп
Гүйцэтгэх захирал



Монгол Улсад даатгалын нэвтрэлт буюу ДНБ-д эзлэх хувь 0.6 хувь байгаа нь дэлхийн дунджаас 10 дахин бага дүн бөгөөд цаашид даатгалын салбар өсөх боломж нэн өндөр байгааг харуулж байна.”

Л.Төр-Од
Монгол даатгал ХК
Гүйцэтгэх захирал




Бид тээвэр ложистикийн өргөтгөсөн дэд бүтэц, Монгол Улсын газар зүйн боломжуудыг ашиглан тээврийн үйлчилгээг бүс нутагт экспортлох замаар өөрсдийн өсөлтийн стратегийг боловсруулан ажиллаж байна.”

Г.Хишигбат
Монложистикс Холдинг
Гүйцэтгэх захирал

ИННОВАЦ, БИЗНЕС, БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ПРОЦЕСС АЛДААТАЙ, ЧАДАВХИ МУУ БАЙНА...

ИННОВАЦ, ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ЗАГВАР “NPD MODEL”



Аливаа салбарын бизнес модель хоцрогдолтой байгаа нь тухайн зах зээлийг авах боломж байна гэж харж байгаа боловч Монголын бизнесүүд олон улсын өрсөлдөхүйц бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн бизнес модель, түүнийг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг судалж үзэхэд хангалтгүй байгаа нь харагдаж байна. Тодруулбал, бизнесүүдийн 50 хувь нь зах зээл, хэрэглэгчээ бүрэн ойлгож судалдаггүй, 64 хувь нь бүтээгдэхүүнийг хэрэглэгч дээр туршихгүйгээр зах зээлд гаргадаг, 75 хувь нь маркетинг кампанит ажлын үр дүнгээ бүрэн хэмждэггүй хэвээр байна.

Олон улсад шинэ бизнес хөгжүүлэлт нь 7 үе шат бүхий процессоор явдаг. Үүнийг дэлхийн топ компаниуд ашигласаар ирсэн бөгөөд бид олон улсад өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхийн тулд энэ загварт суралцах хэрэгтэй. Дэлхийн зах зээлд компаниуд бүтээгдэхүүнээрээ өрсөлддөггүй, харин бизнесээ хөгжүүлэх процессыг хэр чадамгай гүйцэтгэж байгаагаараа өрсөлддөг болохыг ойлгох цаг болсон байна.

БИЗНЕС МОДЕЛИЙГ ӨӨРЧЛӨХ ШААРДЛАГА ҮҮСЭЖ БАЙНА ...

Цаашид компани тогтвортой үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийн тулд бизнес моделийг өөрчлөх шаардлага үүсэж байна. Ингэхдээ ур чадвартай цөөн ажилтнаар ажиллах, технологи ашиглаж бүтээмжийг нэмэгдүүлэх, мөн процессыг автоматжуулах зэрэг хүний нөөцийн оролцоо багатай бизнес моделийг нэвтрүүлэхийг зорьж байна.

MMCG CEO SURVEY 2023


81%

pwc

53%

Ази, Номхон далайн бүсийн CEO нарын 53%, Монголын CEO нарын 81% нь хэрэв одоогийн бизнес моделиор үргэлжлүүлэн ажиллавал ДАРААГИЙН 10 ЖИЛД эдийн засгийн хувьд ҮР АШИГТАЙ БАЙЖ ЧАДАХГҮЙ гэж үзэж байна.

Хэрэв одоогийн бизнес модель, арга замаараа үргэлжлүүлэн ажиллавал, танай компани эдийн засгийн хувьд хэр хугацаанд ашигтай байж чадна гэж бодож байна вэ?



Source: PwC's 26th Annual Global CEO survey, sample: 1,634 CEOs Asia Pacific

БИЗНЕС МОДЕЛИЙГ ӨӨРЧЛӨХ ШААРДЛАГА ҮҮСЭЖ БАЙНА ...



“

Бизнесийн чухал нөөц болох хүний нөөц ойрын жилүүдэд улам бүр үнэтэй, олдоц багатай болсноор ихэнх компаниуд чадварлаг цөөн хүнтэйгээр илүү их баялаг бүтээх өнцгөөс харж, бизнесийн загвараа шинэчлэх шаардлагатай болж байна. Ингэж чадвал цаашид бизнес ч тогтвортой үргэлжилж, Монгол хүний үнэлэмж, үнэ цэнэ ч өснө.”

Л.Гантөмөр
М-Си-Эс Холдинг ХХК
Гүйцэтгэх захирал



“

Технологийн чиг хандлагыг дагаж мөрдөх нь ажилтнуудад хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг илүү сайн ойлгож, шинэлэг шийдлүүдийг санал болгох боломжийг олгодог. Энэ нь тэдэнд бизнесийн боломжит потенциалыг тодорхойлж, өрсөлдөгчдөөсөө түүрүүлэх боломжийг олгодог.”

Кoji Курushima
Мобиком корпораци ХХК
Гүйцэтгэх захирал



“

Бизнес модель болон дижитал шилжилтийн хоцрогдол манай дээр байхгүй ч гэсэн бусад салбаруудад тулгамдаж буй асуудлуудын нэг гэж хардаг. Гэхдээ саад гэхээс илүү боломж гэж харах нь зөв байх. Тэр тусмаа технологи бүтээж байгаа компанийн хувьд энэ бол тэлэлт хийх дотоод зах зээл дээр бүтээгдэхүүн бий болгох боломж.”

Б.Мандуул
ОНДО ХХК
Гүйцэтгэх захирал


ТЕХНОЛОГИ АШИГЛАЖ БҮТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ ГОЛ СТРАТЕГИ БОЛЖ БАЙНА ...

2024-2025 оны компанийн дотоод үйл ажиллагааны стратегийн тэргүүлэх чиглэлийг тодруулахад 58 хувь нь дижитал шилжилт, технологид суурилж бүтээгдэхүүн үйлчилгээгээ хэрэглэгчдэд хүргэх, хэрэглэгчээ таних чиглэлийг дурдаж байна. Үүнээс гадна бизнесийн дотоод процессыг сайжруулах, автоматжуулах, хүний оролцоог багасгах чиглэлээр ажиллаж байна. Мөн хүн төвтэй байх буюу хүний нөөц, байгууллагын чадавх, бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх болон компанийн брэнд, нэр хүндийн асуудлууд багтаж байна. Deloitte-ын судалгаанаас олон улсын компаниудын 67 хувьд нь бизнесийн дотоод процессын шилжилт, өөрчлөлт хийх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Deloitte.

“CEO Survey -2023”

Business Transformation (67%)



Танай компанийн ирэх 2 жилийн дотоод үйл ажиллагааны стратегийн тэргүүлэх чиглэл юу байх вэ? (2024 - 2025)

ТЕХНОЛОГИ АШИГЛАЖ БҮТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ ГОЛ СТРАТЕГИ БОЛЖ БАЙНА ...



“

Бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлж байгаа хамгийн гол зүйл бол дижитал шилжилт, технологи юм. Бид компани дотроо "Digital Champion" гэсэн зорилт тавиад 2018 оноос хойш ажиллаж байна. Үүнд нэлээдгүй хөрөнгө оруулалтууд хийгдсэн учраас эхнээсээ үр дүнгүүд гарч эхэлж байна.”

Г.Амарчингун
Скайтел Групп
Гүйцэтгэх захирал



“

Байгууллага хоорондын харилцааны боломжит бүх түвшинд дижитал шилжилт, автоматжуулалтыг нэвтрүүлснээр бүтээмжээ нэмэгдүүлэх, алдаа гаргах эрсдэлийг бууруулж чадна. Нөгөө талаас хүний оролцоог бууруулж, ажиллах хүчний хомсдолын эрсдэлээс зайлсхийх боломжтой.”

А.Ганболд
Премиум Корпорэйшн
Дэд ерөнхийлөгч



“

Дижитал эдийн засгийг тэлж, дижитал компани болоход бизнесийн байгууллагууд өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, өөрчлөлтөд нээлттэй, дижитал соёлыг бүрдүүлэх нь чухал. Үүнд АйСиТи группийн дижитал эко систем тусална.”

Б.Тамир
Ай СиТи групп
Хамтын ажиллагаа
хариуцсан захирал



“

Банкны салбар цахим шилжилтээр тэргүүлдэг ч гэсэн зогсолтгүйгээр сайжруулах шаардлагатай байдаг. Манай банкны хувьд цаашид цахим банк, процессыг автоматжуулах, AI, Big data аналитик зэрэгт хөрөнгө оруулалтыг тасралтгүй хийсээр байх болно.”


Г.Цэвэгжав
Хас банк ХК
Гүйцэтгэх захирал

BIG DATA ANALYTICS, AI-Д ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ БАЙНА ...

Ирэх нэг жилийн хугацаанд CEO нарын идэвхтэй судалж, хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн технологиудын тэргүүн эгнээнд дата шинжилгээ буюу өөрийн хэрэглэгчийн өгөгдөл дээр суурилан шийдвэр гаргалтаа сайжруулах, түүний дараагаар хиймэл оюун ухаан, робот автоматжуулалт орж байна.

Нийт CEO нарын 60 хувь нь хиймэл оюун ухаанд хөрөнгө оруулна гэж хариулсан бол Deloitte-ын судалгаанд 91 хувь нь тодорхой хэмжээгээр хиймэл оюун ухаанд хөрөнгө оруулна гэсэн байна. Гэхдээ хөрөнгө оруулалтыг бизнесийн үйл ажиллагааны аль үе шатанд хэрэгтэй вэ гэдэг дээр прагматик хандаж, хөрөнгө оруулалтыг хуваарилж байгаа нь харагдаж байна. Тодруулбал, 85 хувь нь урьдчилан таамаглах аналитик, 80 хувь нь нарийвчилсан мэдээллийн аналитик, 50 хувь нь хэрэглэгчдэд тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг автоматаар санал болгох аналитик зэрэгт хөрөнгө оруулахаар төлөвлөж байна.

Шинэ технологиудын алийг нь идэвхтэй судалж, ирэх 1 жилийн хугацаанд үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа вэ?



Deloitte.

“CEO Survey -2023”

Plan to invest AI is 91%

- Key priorities of AI investment:
- Predictive analytics 85%
- Sophisticated Data analytics 80%
- Recommendation engine 50%

BIG DATA ANALYTICS, AI-Д ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ БАЙНА ...



“

Говь ХК олон улсын зах зээлд дэд бүтцээ өргөжүүлэн Европт 2 агуулах, 23 орны хэл дээр онлайн дэлгүүрээ ажиллуулж байна. Жилд 10 сая ам.долларыг гадаад маркетингдаа зарцуулдаг ба Meta, Google зэрэг дэлхийн топ компаниудтай шууд харилцаж бүтээгдэхүүнээ сурталчилж байна.”

Ц.Баатарсайхан
Таван Богд Групп
Ерөнхийлөгч



“

ХААН банк уламжлалт банкны үйлчилгээг халж дижитал банк руу шилжиж, нийт төлбөр тооцооны 99 хувь нь цахимаар хийгдэж байна. Энэ оны эцэст хэрэглээний зээлийн 70 хувь нь цахимаар хийгдэх төлөвтэй байна.”

Р.Мөнхтуяа
ХААН банк ХК
Гүйцэтгэх захирал



“

Мэдээллийн технологийн салбар нь маргаашийн шинэ хэрэглээ, зах зээлийг үүсгэж, урагшилдаг учир өнөөгийн хэрэглэгчдэдээ үйлчилгээгээ маш хямд, эсвэл үнэгүй үзүүлж явах нь түгээмэл. Тиймд энэ салбарын бизнест хөрөнгө оруулалтын боломж, орчин нөхцөлийг шийдвэрлэх хэрэгтэй. Хөрөнгө оруулалт татаж чадсан нь түрүүлж алхдаг.”

Д.Энхбат
Датаком ХХК
Үүсгэн байгуулагч



“

4G сүлжээ нь амьдралын шинэ хэв маяг, шинэ боломжуудыг авчирсан. Одоо бид 21 аймгийн төв талбайд туршилтын станцаа асаан 5G сүлжээ нэвтрүүлэх бэлтгэлээ хангаад байна.”


Д.Жамъяншарав
Юнител групп
Гүйцэтгэх захирал



Гурав.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГОЛ ЧИГЛЭЛ

Монголд аль салбарт хөрөнгө оруулалт хийх сонирхолтой байна вэ?



ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТАТАХААР БАЙНА ...

Уул уурхай бол манай улсын тэргүүлэх чиглэл. Тийм ч учраас Монголд үр өгөөж өндөртэй байна. Хүнсний үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулах хандлага уул уурхайн салбартай ойролцоо түвшинд өндөр байгаа нь анхаарал татахуйц байна. Хүнсний үйлдвэрлэлийн салбар Ковид-19 цар тахлын үеэс хойш илүү тэлсэн бөгөөд дотооддоо өөрсдийн үйлдвэрлэсэн хүнсийг түлхүү хэрэглэх хандлага нэмэгдэж, импортыг орлох хүнсний салбар зах зээлийн боломж потенциал өндөр байгааг харуулж, хүнсний хараат бус байдал нь хөрөнгө оруулалт хийх байдлыг нэмэгдүүлсэн байна.

ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТАТАХААР БАЙНА ...



“

Монгол Улс маань жижиг зах зээлтэй жижиг орон. Бидэнд тодорхой хэмжээнд боломж байна. Хүнсний аюулгүй байдал, хангамж зэрэг төр засгийн хүнсний хувьсгалын бодлогын хүрээнд хүчтэй дэмжлэг орж ирж байна. Бага хүүтэй урт хугацааны зээл, бодлогоор тодорхой хэмжээний дэмжлэгүүдийг үзүүлснээр дотоодын үйлдвэр өсөн дэвшин өргөжих, тэлэх боломж гарч ирнэ.”

Ц.Ганбат
Газар Шим Үйлдвэр ХК
Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал



“

Хөдөө аж ахуйн салбар бол Монгол орны хоёр дахь том экспортын боломж юм. Энэ салбарт шинээр хийх зүйлс, боломж асар их байгаа.”

Ж.Болд
Түмэн шувуут ХК
Гүйцэтгэх захирал



“

Манай салбарт хангалттай боломж бий гэж харж байна. Сүүн бүтээгдэхүүний зах зээл 5-10 жилийн дараа гэхэд жил ирэх тусам томорно. Ирээдүйд энэ хэрэглээ улам нэмэгдэнэ. Монгол Улсын хүн амын хэрэгцээг хангахын тулд энэ зах зээл 3-5 дахин өснө гэж харж байна.”

М.Болод
СҮҮ ХК
Гүйцэтгэх захирал



“

Монгол Улсын нийт экспортын 2 орчим хувийг хүнсний экспорт эзэлдэг. Хэдийгээр экспортын зах зээл нь тээврийн хүндрэлтэй нөхцөлд байгаа ч ТЭСО Групп энэ үзүүлэлтийг 5 орчим хувьд хүргэхээр зорьж буй бөгөөд 2023 онд Монгол Улсаас анх удаа 10 нэр төрлийн зайрмагийг БНХАУ-ын зах зээлд гаргаж эхэлсэн нь хөлдөөсөн бүтээгдэхүүн экспортлох томоохон боломж байгааг илэрхийлж байна.”


С.Болор
ТЭСО Групп
Гүйцэтгэх захирал

ДОТООДЫН ЗАХ ЗЭЭЛД ӨРСӨЛДӨХ БИШ, ХАМТДАА ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛД НЭВТЭРЧ, ЦАР ХҮРЭЭГЭЭ ТЭЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА ...



Өрсөлдөж биш хамтарч, өмчилж биш хуваалцах замаар хамтын үнэ цэнийг бүтээх нь бизнест амжилтын үндэс болдог.”

Д.Бадрал
Шарк



МАК ирэх 30 жилийн хугацаанд эрдэс, металлын шинэ салбарт бизнесээ тэлж буй нь Цагаан суваргын зэсийн орд. Тун удахгүй эдийн засгийн эргэлтэд орох энэ төслийн хүрээнд МАК 2025 он гэхэд жилд 300 мянган тонн баяжмал экспортлохоор төлөвлөж байна. Ингэснээр 1300 гаруй тогтмол ажлын байр шинээр бий болох юм. Түүнээс гадна импортыг орлох чиглэлд Евро стандартын барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлд тасралтгүй хөрөнгө оруулсаар байна.”

Н.Цэлмүүн
Монголын Алт МАК ХХК
Ерөнхийлөгч




Бид дотоодын зах зээл дээр олон улсын компаниудтай өрсөлдөхүйц стратегийн бодлого руу шилжиж байна. Тиймээс импортыг орлох чиглэлд хөрөнгө оруулалтыг оруулж, дэлхийн түвшинд хүрэх зорилготой ажиллаж байна.”

Я.Наваан
Номин Холдинг ХХК
Гүйцэтгэх захирал

ШААРДЛАГАТАЙ САНХҮҮЖИЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТАТАХ ЭХ ҮҮСВЭР ...

Шаардлагатай санхүүжилт, хөрөнгө оруулалт татах эх үүсвэрийг гүйцэтгэх удирдлагуудын 49 хувь нь компанийн өөрийн хуримтлал, ашгаас, 42 хувь нь дотоодын банк, санхүүгийн байгууллагаас, 38 хувь нь олон улсын банк, санхүүгийн байгууллагаас хөрөнгө татахаар төлөвлөж байна.



Дэлхийн томоохон төв банкуудын бодлогын хүү өндөр байсаар байгаа. Үүнээс шалтгаалан хөгжиж буй орнууд хөрөнгийн дутагдалд орж, санхүүжилтийн эх үүсвэр хумигдаж байна. Ийм нөхцөлд Монголд хөрөнгө оруулалт татах нь ихээхэн хүчин чармайлт шаардахаар байна.”

Ш.Алтанбагана

Тера Экспресс ХХК
Гүйцэтгэх захирал


2024 онд ямар эх үүсвэрээс шаардлагатай санхүүжилт, хөрөнгө оруулалтыг татахаар төлөвлөж байна вэ?

40% нь ойрын 3 жилд нээлттэй компани болох төлөвлөгөөтэй байна ...

Судалгаанд хамрагдсан гүйцэтгэх захирлуудын 40 хувь нь ойрын гурван жилд үндсэн болон охин компани нээлттэй компани болгох төлөвлөгөөтэй, 39 хувь нь одоогоор IPO хийх төлөвлөгөөгүй байна.

Цаашид нээлттэй компанийн тоо нэмэгдэх хандлагатай байгаа нь компанийн засаглал сайжрах, хөрөнгө оруулалт татах чиглэлээр нэмэлт эх үүсвэртэй болох, нийгэмд хөрөнгийн тэгш хуваарилалт бий болгох сайн талтай юм.

Танай компани ирэх 3 жилийн хугацаанд нээлттэй компани болох (IPO хийх) төлөвлөгөө байгаа юу?



- Үндсэн компани нээлттэй компани болгоно
- Охин компани нээлттэй компани болгоно
- Үгүй
- Хэлж мэдэхгүй байна
- Өнгөрсөн хугацаанд IPO хийчихсэн



Дөрөв.

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЭРГЭЦ ОЛОН УЛСЫН ДУНДЖААС ӨНДӨР БАЙНА ...

Ажиллах хүчний эргэц 10 хувь байх нь хэвийн түвшин гэж үздэг бол Монголд 19 хувь байгаа нь олон улсын дунджаас хоёр дахин өндөр үзүүлэлт юм. CEO нарын 55 хувь нь ажиллах хүчний эргэц цаашид ч нэмэгдэнэ гэж хариулсан байна. Компанийн хувьд өөрийн ажилтнаа тогтвортой ажиллуулах, ур чадвартай ажилтнаа тогтоон барих чиглэлд хүний нөөцийн бодлого болон компанийн соёлоо сайжруулах, цалин хөлсөө нэмэгдүүлэх, ажиллах орчныг сайжруулах зэрэг олон талт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай нөхцөл байдал үүсэж байна.

Сүүлийн 1 жилд ажиллах хүчний эргэц дунджаар хэдэн хувьтай байсан бэ?

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЭРГЭЦ

19% 

10%
Ideal rate:

2024 ОНД АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЭРГЭЦ

НЭМЭГДЭНЭ


55% 

БУУРНА

45% 

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХОМСДОЛ...

Компаниудад тулгарч буй хүний нөөцийн гол асуултуудыг эрэмбэлэхэд, нийт компаниудын 64 хувь нь ажиллах хүчний хомсдол, ажил хийх хүн олдохгүй байх гэсэн асуудалтай нүүр тулж эхэлсэн байна. 2023 оны “Монголчуудын медиа хэрэглээ, амьдралын хэв маягийн судалгаа”-ны үр дүнгээс харахад оролцогсдын 67 хувь нь боломж олдвол гадагшаа явж ажил хийнэ гэж хариулсан байна. Мөн түүнчлэн ур чадвартай ажилтнуудыг тогтоон барих, олох, цалингийн зардал нэмэгдэх гэсэн асуудлууд бий болсон байна.



Insightful
Innovative
Strategic

“Монголчуудын
медиа хэрэглээ,
амьдралын
хэв маягийн
судалгаа-2023”

67%

Гадагшаа явж ажил
хийх сонирхол
нэмэгдэж байна

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХОМСДОЛ...



Дэлхий даяар ажиллах хүч хомсдож байгаа нь хүний оролцоо ихтэй барилгын салбарт нөлөөлж байна. Тиймээс гаднаас ажиллах хүч авах бодлогыг эргэн харах, хүний оролцоог багасгах технологийн дэвшлийг нэвтрүүлэх шаардлага улам бүр нэмэгдсээр байна.”

Б.Хүрэлхүү
NCD групп ХХК
Гүйцэтгэх захирал



Цар тахлаас хойш бүтэн цагийн ажиллах хүч хомсдолд орсон. Тиймээс цагийн систем рүү шилжиж, ажилтан өөрийн цалин хөлсийг хүссэн хэмжээндээ менежмент хийх, ажил олгогч шаардлагатай бүтээмжийг богино хугацаанд авах аль аль талдаа үр ашигтай байх системийн шинэчлэлийг хийх цаг нь иржээ.”

Г.Батбаяр
Монкон Констракшн ХХК
Гүйцэтгэх захирал



Бид хүний нөөцөө тогтвортой авч явахын тулд бусад улс орны компаниудтай өрсөлддөг цаг ирээд байна. Ирэх жилүүдэд хүн нь ажилд орох гэж ярилцлагад ордог биш компаниуд нь сайн хүний нөөцийн төлөө өрсөлддөг үе ирж байна.”

Б.Гантулга
Улаанбаатар Үнэт Цаасны бирж ХК
Гүйцэтгэх захирал

ЦАЛИН 2024 ОНД ДАХИН ӨСӨХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА ...

2023 онд цалингийн өсөлт дунджаар 24 хувьтай байсан бол ирэх жил ч үргэлжлүүлэн өснө гэдэгт гүйцэтгэх захирлууд санал нэгдэж байна. Ур чадвартай ажилтныг хадгалах, татахын тулд өрсөлдөхүйц цалин, урамшуулал, хангамж олгох, сурч хөгжих боломжийг бүрдүүлэхээр төлөвлөж байна.

Цалингаас гадна соёлоороо өрсөлдөж, ажиллагчдын хүсэмжит байгууллага байхын тулд ажилтан төвтэй болох нь чухал гэдгийг онцолсон байна. Тийм учраас байгууллагын хувьд соёлдоо анхаарах цаг үе нь ирсэн байна.

ЧАДВАРЛАГ АЖИЛТНЫГ ХАДГАЛАХ, ТАТАХ БОДЛОГО



24%

ЦАЛИН ӨСӨЛТ, 2023

ЦАЛИН 2024 ОНД ДАХИН ӨСӨХ
ТӨЛӨВТЭЙ БАЙНА ...



“

Сүүлийн жилүүдэд үйл ажиллагааны зардал дотроо хүний нөөцийн зардал нэлээн өсөж байна. Ажиллах хүч цалин өндөр газар руу шилжиж ажиллах нь түгээмэл байгаа бөгөөд Солонгос улс руу их явдаг болсон. Тиймээс хүмүүсээ тогтоон барихын тулд өрсөлдөхүйц цалин, урамшуулал, хангамж олгох үүднээс сүүлийн 2 жилийн хугацаанд цалингаа 2.5 дахин нэмсэн байна. Мөн бид дан ганц хүний нөөц гэхээс илүүтэй HCM гэдэг зүйл рүү явж байна. Энэ нь “Human Capital Management” гэсэн үг. Дэлхийн томоохон компаниуд хэрэгжүүлдэг бөгөөд зөв хүмүүсийг ажилд авах, ажиллах хүчнийг үр дүнтэй удирдах, бүтээмжийг оновчтой болгох гэсэн ойлголт юм.

Г.Амарчингүн
Скайтел Групп
Гүйцэтгэх захирал



“

Чадварлаг ажилтан авсан бол өрсөлдөхүйц цалин, хангамжийг өгөх ёстой. Зах зээлийн хуулиараа л явах ёстой учраас цаашид ч цалингийн өсөлт хийгдэх байх. Манайд “ТЭСО академи” гэж ажилладаг. Ур чадвартай хүмүүсийг авахын зэрэгцээ сурч хөгжих хүсэлтэй залуучуудыг авч ажиллуулдаг. Мөн дан ганц цалин хангамжаар асуудал шийдэгдэхгүй тул эерэг таатай байгууллагын соёл бүрдүүлнэ гэдэг зүйл байна. Ойлгомжгүй, эрүүл бус байдал, бизнесийн ёс зүй нь сөрөг, хортой байвал тэнд ажлын бүтээмж нэмэгдэхгүй, байгууллагын эерэг зөв соёл бий болохгүй. Тэгэхээр мөн оновчтой зөв удирдлагаар хангах шаардлагатай.”

С.Болор
ТЭСО Групп
Гүйцэтгэх захирал

**ЭЭРЭГ ТААТАЙ
БАЙГУУЛЛАГЫН
СОЁЛЫГ
БҮРДҮҮЛЭХ НЬ
ЧУХАЛ ...**

“



Бид ажиллах таатай орчин, уян хатан, зайнаас ажиллах, сурч хөгжих боломжийг бүрдүүлэхээр эерэг соёл, оновчтой зөв удирдлагаар ханган ажиллаж байна. “Соёлын элчийн хөтөлбөр”-ийг дотооддоо сүүлийн 3-5 жил хэрэгжүүлж байна. Том байгууллагыг “Байгууллагын соёл” удирддаг гэж үзэн ажилтнуудын ажиллах дуртай байгууллага байлгах зорилгоор соёлоо сайжруулахад бүх анхаарлаа хандуулдаг.”

Р.Мөнхтуяа
ХААН банк ХК
Гүйцэтгэх захирал

“



Манайх дотооддоо “НЭКСТ академи”-тай бөгөөд сургагч багш нараар тасралтгүй сургалт ороод явж байна. Энэ нь ажилтнуудын сурч хөгжих боломжийг нь олгохын зэрэгцээ ур чадварын тал дээр анхаарч байгаа нэг хэрэг. Зайнаас ажиллахтай холбогдуулаад уян хатан цагаар ажилладаг нэгжүүд ч байна, оффис дээр ирж ажиллах хэсэг ч байна. Тэгэхээр оффис дээр заавал ирж суух шаардлагагүй бол зайнаас ажиллаж болох ажлын онцлогоос шалтгаалсан уян хатан цагаар ажиллах гэрээнүүдийг хийх боломжуудыг бүрдүүлсэн.”

Л.Чулуунболд
Нэкт Групп
Ерөнхийлөгч

“



Ажилд орохоор ирж буй ажилтан бүрийг компанидаа хэрхэн нутагшуулж авах вэ гэдэг хамгийн том асуудал болж байна. Хүний нөөцийн асуудал дахиад 4-5 жил үргэлжлэх хандлагатай байна. Шинээр ирэх хүн бүрийг халуун дотноор хүлээн авч, компанидаа хэрхэн хурдан дасгах вэ гэдэг манай хүний нөөцийн алба, бидний ярьдаг байнгын сэдэв болсон. Дунд шатныхан шинээр орж ирж буй ажилтантай болгоомжгүй харьцсанаас болж Z үеийнхэн өнөөдөр ирээд маргааш явж байна. Тэгэхээр технологи шингээсэн, автоматажсан компани болох чиглэлтэй ажиллаж байна.”

С.Болорсайхан
Витафит милк ХХК
Гүйцэтгэх захирал



Тав.

ГОЛ ДҮГНЭЛТ

ТООНООС ИЛҮҮ СУУРЬ НӨХЦӨЛ БАЙДАЛД АНХААРЛАА ХАНДУУЛЪЯ, “NO NEED SUGAR COATING”


01

2024 онд эдийн засгийн ерөнхий үзүүлэлтүүд сайн байх мэт харагдаж байгаа ч бизнесийн үйл ажиллагаа явуулах, бизнесийн өсөлтийг хийх суурь нөхцөл байдал сайнгүй байна.

Харин гадаад нөхцөл байдал талаас БНХАУ-ын эдийн засгийн уналт, худалдааны дайн, Орос-Украины дайны тодорхойгүй нөхцөл, тээвэр, логистикийн асуудал байсаар байна.

Бизнесийн өсөлтийг хязгаарлаж болзошгүй дотоод суурь асуудлуудыг харвал хүний нөөцийн хомсдол, төрийн зөвшөөрөл, тодорхой бус шийдвэрүүд, эрчим хүч, дэд бүтцийн хязгаарлалтууд бизнесийн өсөлтийг хязгаарлах хүчин зүйлс болж байна. Тиймээс дээрх суурь асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх тал дээр макро түвшний бодлогуудыг хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Дэлхийн эдийн засгийн бусад тайлангуудаас харахад уур амьсгал, байгаль орчны эрсдэл зэрэг асуудлууд маш хүндэрч эхэлж байгаа бөгөөд эдгээр нь эргээд бизнесийн өсөлт, тогтвортой байдалд нөлөөлж байгааг дурдаж байсан. Монголын нөхцөлд одоохондоо эдгээр асуудлуудыг хөндөөгүй боловч цаашид анхаарах асуудлуудын нэг мөн юм.



ДЭЛХИЙ БИЗНЕС МОДЕЛЬ, ПРОЦЕССООР ӨРСӨЛДДӨГ, “МОНГОЛЧЛОХОД ХЯЗГААР БИЙ”

02

Өсөлтийн гол стратеги бол инновац гэж харж байгаа ч бизнес хөгжүүлэлтийн процесст судалгаа шинжилгээ хангалтгүй, креатив санааг дэмждэггүй, хэрэглэгч биш захирал төвтэй байсаар байна.

Бизнесүүдийн 50 хувь нь зорилтот хэрэглэгчээ судлахгүй, 64 хувь нь бүтээгдэхүүнээ туршихгүй, 75 хувь нь зах зээлд гарснаас хойш хэмжихгүй байгаа нь бизнес хөгжүүлэлтийн процесс хоцрогдолтой байгааг харуулж байна.

Дэлхийн зах зээлд компаниуд бүтээгдэхүүнээрээ өрсөлддөггүй, харин түүнийг бүтээх стандарт, процессыг хэрхэн судалгаа шинжилгээтэй, хэрэглэгч төвтэй, мэргэжлийн өндөр түвшинд хийж чадаж байгаагаар болон бизнес процессын бүтээмж, үр дүнтэй байдлаараа өрсөлддөг болохыг ойлгох цаг болсон байна.

Глобал түвшний тайлангуудаас харахад технологийн дэвшилтэт асуудлууд болон хэрэглэгчийн амьдралын хэв маягийн томоохон өөрчлөлтүүд зэргээс шалтгаалан цаашид бизнес моделийн шилжилт, алсын хараагаа сайжруулж, шинэчлэх зайлшгүй нөхцөл байдал үүссэн байна. Одоогийн бизнес моделиор явахад ойрын 5 жилдээ эдийн засгийн үр өгөөжгүй болно гэж нийт CEO нарын 51 хувь нь үзэж байна.

ТИЙМЭЭС ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ, БИЗНЕС ПРОЦЕССЫН АВТОМАТЖУУЛАЛТ,
БҮТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХИЙН ЗЭРЭГЦЭЭ ХҮН ТӨВТЭЙ БАЙХ НЬ
СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ БОЛЖ БАЙНА.

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХОМСДОЛ, “HUMAN RESOURCE SCARCITY BATTLE”...

03

Ажиллах хүчний эргэц 19 хувь байгаа нь хэвийн түвшнээс хоёр дахин өндөр ба цаашид мөн нэмэгдэнэ гэж CEO нарын 55 хувь нь үзсэн байна.

Идэвхтэй хүн амын 60 хувь нь гадаадад ажиллах сонирхолтой, ажил олгогчдын 64 хувь нь ажиллах хүчний хомсдол үүссэн буюу ажил хийх хүн олдохгүй байх гэсэн асуудалтай нүүр тулж эхэлсэн байна.

Өнгөрсөн онд цалингийн өсөлт дунджаар 24 хувьтай байсан бол ирэх жил ч үргэлжлүүлэн дахин өснө гэдэгт мөн адил CEO нар санал нэгдэж байгаа юм.

Ажилтны сэтгэл ханамж өндөртэй, ажиллагсдын хүсэмжит байгууллага байхын тулд засаглалаа ажилтан төвтэй болгох ёстой.

Мөн компанийн хувьд өөрийн ажилтнаа тогтвортой ажиллуулах, ур чадвартай ажилтнаа тогтоон барих чиглэлд хүний нөөцийн бодлого болон компанийн соёлоо сайжруулах, цалин хөлсөө нэмэгдүүлэх, ажиллах орчныг сайжруулах зэрэг олон талт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай цаг үе нь ирсэн байна.

ИЙМ УЧРААС ЦААШИД ДИЖИТАЛ ШИЛЖИЛТИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХИЙХ,
БАГА ХҮНЭЭР ӨНДӨР БҮТЭЭМЖТЭЙ АЖИЛЛАДАГ БИЗНЕС МОДЕЛЬД
ШИЛЖИХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.



Монгол орны онгон зэрлэг ойд ургадаг хуш модны самар нь байгалийн эрс тэс уур амьсгал, хатуу ширүүн нөхцөлийг даван туулж боловсордог тул шимт бодис болон уургийн агууламж өндөртэй байдаг.

- Омега 3,6,9 агууламж өндөр
- Хөгшрөлтийг удаашруулах үйлчилгээтэй
- Ханаагүй тосны хүчил нь зүрх судасны өвчний эрсдэлийг бууруулдаг
- Хүний биеийн уургийн дутагдлыг нөхөж, дархлааг сайжруулдаг
- Самарт агуулагддаг ургамлын уураг нь хүний биед 100% шингэдэг
- E болон F төрлийн амин дэм нь эхийн хөхний сүүг нэмэгдүүлдэг зэрэг маш олон төрлийн ашиг тустай байгалийн цэвэр бүтээгдэхүүн юм.

“Хушхан” брэнд HACCP, ISO22000:2018, ISO 9001:2015 стандартуудыг хэрэгжүүлж амжилттай баталгаажуулан түүхий эд хүлээн авахаас эхлэн бэлэн бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн гарт хүргэх хүртэл үйл ажиллагаандаа чанар, хүнсний аюулгүй байдлын шаардлага ханган ажиллаж байна.

“Хушхан” брэндийн самар, чөмөг 3 цехийн 20 шат дамжлагаар дамжин боловсорч эрүүл, аюулгүй цэвэрхэн, шинэхэнээрээ таны гарт хүрдэг.

**АНТИОКСИДАНТААР БАЯЛАГ ТУЛ
БИЕИЙГ ХОРГҮЙЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ.**



MONGOLIAN NATURAL PINE NUTS

+976 7717 3399

info@nordroad.mn

ХУД 15-р хороо Их Монгол улсын гудамж 61

Юник центр 4-410 тоот





Insightful
Innovative
Strategic

Хан-Уул дүүрэг, 18-р хороо Парк Гарден плаза,
12-р давхар Улаанбаатар хот, Монгол Улс

www.mmcg.mn

Судалгаа, төлөвлөлтийн газар
Мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын газар

Утас/Факс: 976-77000188

И-мэйл: info@mmcg.mn